



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 26 дугаар хуралдааны тэмдэглэлд:

26.22.ХЭЛЭЛЦСЭН нь:

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 23 дугаар байр (8 машины гарааш)-ыг дахин төлөвлөлтөд хамруулах тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Гадаад харилцааны сайдын 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын багцад дотоодын болон гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, олон улсын байгууллагуудын албан уулзалт, хурал цуглаан зохион байгуулах, албан бус арга хэмжээгээр дамжуулан харилцаагаа бэхжүүлэх, гадаадын Дипломат төлөөлөгчийн газруудад чиглэсэн үйлчилгээ үзүүлэх зорилготой “Дипломат корпус-Олон улсын мэдээлэл солилцоо, ёслол, арга хэмжээний төв”-ийн барилга барихаар төсвийн төсөлд тусгуулсан байна.

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын эзэмшилд байгаа нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Олимпын гудамж 10 тоотод байрлалтай, 000002003 дугаартай эрхийн гэрчилгээтэй, 4905 м.кв талбай бүхий газарт дээрх барилгыг барихаар төлөвлөж зураг төсөл хийсэн байна.

Иймд “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын шаардлага хангахгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд ашиггүй 23 дугаар байр (8 машины гарааш)-ыг буулгаж оронд нь улсын төсвийн санхүүжилтээр төрийн өмчийн барилга барих дахин төлөвлөлтийн асуудлыг дэмжих нь зүйтэй гэж үзэв” гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

